

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР, ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН АСУУДАЛ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2007 оны 08 сарын 18 өдөр

Дугаар 66/46

Улаанбаатар хот

Иргэний бүртгэл, паспорт хяналтын нэгдсэн
сүлжээг хамтарч ашиглах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 65 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2007 оны 99 дугаар тушаалыг үндэслэн "Иргэний бүртгэл, паспорт хяналтын нэгдсэн сүлжээ"-ний компьютер, тоног төхөөрөмжийн байнгын, тогтвортой үйл ажиллагааг ханган ажиллахын тулд ТУШААХ НЬ:

1.Нэгдсэн сүлжээнд холбон ашиглаж байгаа зориулалтын компьютер, тоног төхөөрөмжийг зайлшгүй шалтгаанаар унтраах, салгах тохиолдолд холбогдох ажилтнуудад харилцан урьдчилан мэдэгддэг журмыг мөрдөж ажилласугай.

2.Нэгдсэн сүлжээний байнгын тогтвортой ажиллагааг хангаж ажиллахыг Хил хамгаалах ерөнхий газрын Холбооны хэлтсийн дарга, дэд хурандаа Н.Урьдынбиш, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын Мэдээллийн технологийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Х.Энхжаргал нарт даалгасугай

3.Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Хил хамгаалах ерөнхий газрын тэргүүн дэд бөгөөд ХЦ-ийн штабын дарга, бригадын генерал А.Лхагвасүрэн, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын дэд дарга бөгөөд Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Х.Гэрэлчулуун нарт үүрэг болгосугай

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА ХИЛНИЙ ЦЭРГИЙН
КОМАНДАГЧ БРИГАДЫН ГЕНЕРАЛ



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
АСУУДАЛ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Д.МӨРӨН